



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/649

Булган сум

### Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн XVII/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Цэвэр усан хангамжийн нэгдсэн системийг шинээр байгуулах (Булган сум, Рашаант баг) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Эрингүрэн” ХХК-тай 495 174 258 (дөрвөн зуун ерэн таван сая нэг зуун далан дөрвөн мянга хоёр зуун тавин найм) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Эрингүрэн” ХХК-ийн захирал (М.Жаргалсайхан)-д даалгасугай.

4. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны  
09 дугаар сарын 13-ны өдрийн  
А/649 дугаар захирамжийн хавсралт

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	7,972,772	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн албаны зардал	7,972,772	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал	3,986,386	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	36,022,312	Ү.Бямбасүрэн
5	Нормчлолын сан	717,549	Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.1 хувь, нийт алданги гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
7	Ажил гүйцэтгэх хугацаа	270 хоног	Ү.Бямбасүрэн
8	Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь байна.	Д.Батцогт